

### НЭГДҮГЭЭР ХЭСЭГ. СОНГОХ ДААЛГАВАР

#### Санамж:

1. Зохиолын хэсгийг анхааралтай уншиж, ойлгоорой.
2. Асуулт даалгавар бүрийг анхааралтай, дуустал уншиж гүйцэтгээрэй.
3. Сонгож авсан үг, өгүүлбэрийг зохиолын хэсгийн утга санаатай холбож ажиглаарай.
4. Сонгох даалгавраас зөвхөн нэгийг сонгоорой. /Даалгавар бүр 2 оноотой/

#### “Ус уухын заяа”

**Шарга морь чихээ сортолзуулан үргэж цочсон харцаар ийш тийш сэрвэлзэн харж, цэрвэн алхалсаар онгоцтой ус руу хүзүү сунган орж ирлээ. Хөлсөө дусалтал гүйсэн тэр адгуус онгоцны булангаас хүзүүгээ гүрэлзүүлэн ус залгилснаа алсын анир сонсов уу гэлтэй эргэж харлаа. Ёстой л уядаг хүн уямаар, гоёдог хүн гоёмоор, хуучин эмээл тохвол алдас болж гологдмоор сайхан амьтан байлаа.**

Би шарга морийг цулбуураа ороон оосорлож авбал нэгээхэн ч үргэж зуларсангүй, буруу зөвгүй номхон амьтан ажээ. Нутаг ус, ижил сүргээ тэмцэн гүйж яваа энэ амьтныг замын элдэв муу хүмүүс битгий хоргоож саатуулаасай гэхдээ нутгийн нэгэн настанд барьж золгохоор авч явсан “аюуш” хадгаа өврөөсөө гарган хур дэлэнд нь алдуурч осолдохооргүй зангидан уялаа. Шарга морь газар үнэрлэн дороо эргэцэн зогссоноо нэгэнтээ цанхаалан санаа алдлаа.

Тэгснээ худгийн цулгай шороон дээр хөрвөөж аян замын алжаал тоосоо нэгэнтээ шилгээн унагаагаад сэтгэл шулуудсан бололтой эргэж ч харалгүй товор товор алхан одлоо. Энэ хэлгүй адгуус альхан нутгийн газар шороог ертөнцөөс нэхэн нэхэн ийнхүү өдөр, шөнийг эс ялган өртөөлөн гүйж явааг явуулын хүн миний бие яахан мэднэм билээ.

Мөнөөх гал шарга морь холын уулсыг өндөлзтөл хатиран хатирсаар харцнаас алдууран агь сэнгэнэсэн бүгээн хонгор талын хаяанаа үзэгдэхтэй үгүйтэй болсноо бараа тасран одлоо.

/Б.Догмид/

1. Шарга морины дэлэнд хадаг зүүсний учир юу вэ?
  - A. Уядаг хүн уямаар, гоёдог хүн гоёмоор, хуучин эмээл тохвол алдас болж гологдмоор сайхан амьтан байсан учраас
  - B. Нутаг ус, ижил сүргээ тэмцэн гүйж явах замд нь элдэв муу хүмүүс бүү хоргоож саатуулаасай гэж бодсон учраас
  - C. Газар үнэрлэн дороо эргэцэн зогссоноо нэгэнтээ цанхаалан санаа алдсаныг нь харсан учраас
  - D. Хөлсөө дусалтал гүйсэн тэр адгуус хүзүүгээ гүрэлзүүлэн ус залгилж байсныг харсан учир
  - E. Шарга морийг цулбуураа ороон оосорлож авахад буруу зөвгүй номхон амьтан байсан учраас
2. Эхийн тодруулсан цогцолбор утгын ямар зүйлчлэлд хамаарах вэ?
  - A. Адгуусны бүтээсэн
  - B. Хүний бүтээсэн
  - C. Адгуусны
  - D. Сэтгэхүйн
  - E. Гараг эрхсийн
3. “Энэ хэлгүй адгуус альхан нутгийн газар шороог ертөнцөөс нэхэн нэхэн **ийнхүү** өдөр, шөнийг эс ялган өртөөлөн гүйж явааг явуулын хүн миний бие яахан мэднэм билээ”- онцолсон үг эхийн аль үйл явдалтай **холбогдохгүй** вэ?
  - A. Шарга морь газар үнэрлэн дороо эргэцэн зогссоноо нэгэнтээ цанхаалан санаа алдлаа.
  - B. Агь сэнгэнэсэн бүгээн хонгор талын хаяанаа үзэгдэхтэй үгүйтэй болсноо бараа тасран одлоо.
  - C. Сэтгэл шулуудсан бололтой эргэж ч харалгүй товор товор алхан одлоо.
  - D. Мөнөөх гал шарга морь холын уулсыг өндөлзтөл хатиран хатирсаар харцнаас алдуурлаа.
  - E. Нутгийн нэгэн настанд барьж золгохоор авч явсан “аюуш” хадгаа өврөөсөө гаргалаа.
4. Дээрх эхийн сэдвийг илэрхийлсэн хэлцийг олоорой.
  - A. Морь эмээлтэй, мод баадантай
  - B. Адууг уургаар, ааштыг аргаар
  - C. Хүлгийн сайныг унан байж мэднэ
  - D. Адуугаа дагасан даага албанд унах морь болдог
  - E. Хүлгийн хүү төрсөндөө гүйдэг, хүний хүү нутагтаа суудаг

5. Эхийн гол санааг илэрхийлэх тулгуур өгүүлбэрийг олоорой.
- A. Нутаг ус, ижил сүргээ тэмцэн гүйж яваа энэ амьтныг замын элдэв муу хүмүүс битгий хоргоож саатуулаасай.  
 B. Шарга морь чихээ сортолзуулан үргэж цочсон харцаар ийш тийш сэрвэлзэн харж, цэрвэн алхалсаар онгоцтой ус руу хүзүү сунган орж ирлээ.  
 C. Энэ хэлгүй адгуус альхан нутгийн газар шороог ертөнцөөс нэхэн нэхэн ийнхүү өдөр, шөнийг эс ялган өртөөлөн гүйж яваа бол.  
 D. Ёстой л уядаг хүн уямаар, гоёдог хүн гоёмоор, хуучин эмээл тохвол алдас болж гологдмоор сайхан амьтан байлаа.  
 E. Би шарга морийг цулбуураа ороон оосорлож авбал нэгээхэн ч үргэж зуларсангүй, буруу зөвгүй номхон амьтан ажээ.
6. Эхийн хэв маягийг зөв тодорхойлсныг олоорой.
- A. Эргэцүүлэмж  
 B. Тоочимж  
 C. Тайлбарламж  
 D. Хүүрнэмж  
 E. Эргэцүүлэмж, тайлбарламж хосолсон
7. “Би шарга морийг цулбуураа ороон оосорлож авбал нэгээхэн ч үргэсэнгүй” - өгүүлбэрээс хоёр бүрэлдэхүүнт цөм бүтцийг олоорой.
- A. Би оосорлоно.  
 B. Морийг оосорлоно.  
 C. Би орооно.  
 D. Цулбуураа орооно.  
 E. Морь үргэнэ.
8. Утгын зүйлчлэл талаас бусдаасаа өвөрмөц өгүүлбэрийг олоорой.
- A. Газар үнэрлэх  
 B. Ус залгилах  
 C. Чихээ сортолзуулах  
 D. Үргэж зулрах  
 E. Агь сэнгэнэсэн
9. Бахархсан өнгө аястай хэсгийг олоорой.
- A. ...буруу зөвгүй номхон амьтан ажээ.  
 B. ...Нутаг ус, ижил сүргээ тэмцэн гүйж яваа энэ амьтныг замын элдэв муу хүмүүс битгий хоргоож саатуулаасай.  
 C. ...“аюуш” хадгаа өврөөсөө гарган хур дэлэнд нь алдуурч осолдохооргүй зангидан уялаа.  
 D. Ёстой л уядаг хүн уямаар, гоёдог хүн гоёмоор, хуучин эмээл тохвол алдас болж гологдмоор сайхан амьтан байлаа.  
 E. ...явуулын хүн миний бие яахан мэднэм билээ.
10. “Аюуш” хадгаа хур дэлэнд нь уялаа - өгүүлбэрийн өгүүлэхүүнийг захирах төлөвт хувиргасныг сонгоорой.
- A. уяасай  
 B. уя  
 C. уяна  
 D. уясан сан  
 E. уясан уу
11. “Сэтгэл шулуудсан бололтой эргэж ч харалгүй товор товор алхан одлоо” - өгүүлбэрийг салаалан хувиргасан нь аль вэ?
- A. Сэтгэл шулуудсан бололтой эргэж ч харахгүй товор товор алхан одсон уу?  
 B. Сэтгэл шулуудсан бололтой эргэж ч харалгүй товор товор хатирсаар толгод даван одов.  
 C. Сэтгэл шулуудсан бололтой эргэж ч харалгүй алхан одлоо.  
 D. Тэгснээ худгийн цулгай шороон дээр хөрвөөж аян замын алжаал тоосоо нэгэнтээ шилгээн унагаагаад сэтгэл шулуудсан бололтой эргэж ч харалгүй товор товор алхан одлоо.  
 E. Эргэж ч харалгүй товор товор алхан одсон нь сэтгэл шулуудсаных бололтой.
12. Найруулгын алдаатай өгүүлбэрийг олоорой.
- A. Зуны дунд сарын арван тавнаа үдшийн сар өвлийнхтэй яахан адил байдаг сан билээ.  
 B. Тушиж холбосон гурван морь минь гэрэлд нэгэнтээ тодрон харагдсанаа төдхөн харанхуйд залгигдах мэт үзэгдэхгүй болно.  
 C. Цагаан тос нь нягт сайн шахаж хураавал хөгцрөхгүйгээр өвлийн улиралтай золгодог.  
 D. Нялхын үнэрээ гээгээгүй зулайг нь үнэрлэв.  
 E. Тэр олон айлын гаднаас майн утаа бургилан Сэрүүний гол дээр нийлж, үүл манан мэт хөвөлзөн суунаглана.
13. “...буруу зөвгүй номхон амьтан ажээ” - өгүүлбэрийн утгад тохирох хэлцийг олоорой.
- A. Номхон морины ногт болох  
 B. Их мөрөн дөлгөөн  
 C. Хонины морь шиг  
 D. Номхон моринд эзэн олон  
 E. Номхон морь ногтолж чадахгүй

14. “Авч явсан “аюуш” хадгаа өврөөсөө гарган хур дэлэнд нь алдуурч осолдохооргүй зангидан уялаа” - өгүүлбэрийн шууд тусагдахуун гишүүнийг олоорой.  
 А. хадгаа      В. гарган      С. өврөөсөө      D. хур дэлэнд нь      E. алдуурч осолдохооргүй
15. “Ёстой л уядаг хүн уямаар, гоёдог хүн гоёмоор, хуучин эмээл тохвол алдас болж гологдмоор” - гэдэгтэй эсрэг санаат өгүүлбэрийг олоорой.  
 А. Дэжид хайдаг гунжаа дахин ажиглаж, нүд хужирлахаар гадаа гарав.  
 В. Нүдэнд дулаахан хархүү та нүүдлийн шувуу байсан юм уу?  
 С. Одоо хүү минь өөхөн доторх бөөр шиг л байдаг сурагтай.  
 D. Цавьдар үрээ чухам л ганзага цацалсан, цохилсон хар алхаатай, зурмал хөрөг шиг сайхан амьтан байж билээ.  
 E. Өөхөнд ороовч нохой шиншихгүй юм надад өгсөн.
16. “Шарга морь чихээ сортолзуулан үргэж цочсон харцаар ийш тийш сэрвэлзэн харж, цэрвэн алхалсаар...” – хэсэгт дүрсэлсэн гал шарга морины зан байдалтай тохирохыг олоорой.  
 А. Сэрэмжтэй явбал аминд тустай      В. Үргэсэн моринд ташуур олон  
 С. Айсан хүнд аргал хөдөлнө      D. Аймхай морь үргэмтгий  
 E. Цочсон нохой цохноос айх
17. “Уядаг хүн уямаар, гоёдог хүн гоёмоор” - өгүүлбэрийн хэв шинжийг тодорхойлоорой.  
 А. Нэрийн хамжсан тодотгол гишүүн өгүүлбэртэй угсарсан нийлмэл өгүүлбэр  
 В. Үйлийн хамжсан тодотгол гишүүн өгүүлбэртэй угсарсан нийлмэл өгүүлбэр  
 С. Цагийн байц гишүүн өгүүлбэртэй угсарсан нийлмэл өгүүлбэр  
 D. Холимог нийлмэл өгүүлбэр  
 E. Зэрэгцсэн нийлмэл өгүүлбэр
18. “Нутаг ус, ижил сүрэг рүүгээ **гүйж яваа** энэ амьтныг замын элдэв муу хүмүүс битгий хоргоож саатуулаасай” - онцолсон өгүүлэхүүнийг яаж хувиргавал байц гишүүн өгүүлбэртэй угсарсан нийлмэл өгүүлбэр болох вэ?  
 А. гүйж явах      В. гүйж явдаг      С. гүйж яван      D. гүйж явангаа      E. гүйж явахад нь
19. “Мөнөөх гал шарга морь холын уулсыг өндөлзтөл хатиран хатирсаар...” гэсэн хэсэгт уулсыг өндөлзөнө хэмээн амьдчилан дүрсэлсэн нь хэр оновчтой вэ?  
 А. Уулыг өндөлзүүлэн хөдөлгөх чадал ямар ч амьтанд үгүй тул энэхүү дүрслэл оновчгүй болжээ.  
 В. Сэтгэл хөглөм хатирах ган дөрвөн туурайг холын уулс өндөлзөн харна хэмээн амьдчилсан нь оновчтой болжээ.  
 С. Шарга морь нутгаа тэмүүлэн гүйж явааг нь уулс өндөлзөхтэй зүйрлэн дүрсэлсэн нь оновчтой болжээ.  
 D. Шарга морины хатираанд уул хөдлөөд байгаа юм шиг харагдахыг дүрслэхдээ өндөлзөнө хэмээх үгийг буруу сонгожээ.  
 E. Холын уулс биш ойрын уул гэж дүрсэлсэн бол илүү сайн болох байж.
20. Тусах, үүсмэл, өөрөө үйлдэх хэв, энгийн үйлдэх байдал, зэрэгцэх тийн ялгалын нөхцөлтэй үйл үгийг олоорой.  
 А. сортолзуулан      В. оосорлож      С. алхалсаар      D. үргэж      E. унагаагаад
21. Бүгд гурван үе бүхий бүлэг үгийг олоорой.  
 А. Сэрвэлзэн, дусалтал, өртөөлөн, шулуудсан, үнэрлэн  
 В. Алхалсаар, унагаагаад, үгүйтэй, цанхаалан, тохвол  
 С. Сортолзуулан, гоёдог, булангаас, золгохоор, хатирсаар  
 D. Эргэцэн, уямаар, сэнгэнэсэн, саатуулаасай, хуучин  
 E. Үзэгдэхтэй, гүрэлзүүлэн, алдуулан, гарган, нэгэнтээ
22. “Хуучин эмээл тохвол **алдас болж** гологдмоор сайхан амьтан байлаа” - тодруулсан хэсгийг солин найруулбал аль нь тохиромжтой вэ?  
 А. нүд болж      В. гай болж      С. буян болж      D. зовлон болж      E. алдаа болж
23. “Сэтгэл шулуудсан **боллолтой** эргэж ч харалгүй товор товор алхан одлоо” - онцолсон баймжтай утга ойролцоо үгийг олоорой.  
 А. болзошгүй      В. байдалтай      С. учраас      D. царай нь      E. завшаанаар

24. "...Тэгснээ худгийн цулгай шороон дээр хөрвөөж аян замын алжаал тоосоо нэгэнтээ шилгээн унагаагаад сэтгэл шулуудсан бололтой эргэж ч харалгүй товор товор алхан одлоо" - тодруулсан холбоосыг тохирох үгээр солин найруулаарай.  
 А. Түүнчлэн В. Мөн С. Харин D. Тэгээд E. Тухайлбал
25. Эхийн өгүүлбэрүүдээс найруулгын дээд зэрэгт хувиргасныг олоорой.  
 А. "аюуш" хадаг гарган В. харцнаас алдууран С. агь сэнгэнэсэн  
 D. гал шарга хүлэг хатиран E. хүзүүгээ гүрэлзүүлэн
26. "Шарга морь чихээ сортолзуулан үргэж цочсон харцаар ийш тийш сэрвэлзэн харж" өгүүлбэрт **ороогүй** үгийн аймгийг олоорой.  
 А. Тооны нэр В. Жинхэнэ нэр С. Үйл үг D. Орон цагийн нэр E. Тэмдэг нэр
27. Чөлөөт бус холбоо үгсийн зүй тогтлыг ажиглаад цэгийн оронд тохирохыг нөхөөрэй.  
 Орж ирлээ, газар шороо, шороон дээр, нутаг ус, алхан одлоо, аян зам, .....  
 А. ийш тийш В. тэр адгуус С. буруу зөвгүй D. нэгэн настан E. хатиран хатирсаар
28. "Зарим нь тэрэгнийхээ арлыг даавуу навтсаар бүтээн **оромж** босгожээ",  
 "Онон мөрний эрэгт буй их **өргөөнөө** хүрч очив" – өгүүлбэрүүдэд гэр хэмээх үгийг найруулгын зэргээр хувирган бичсэнийг хэрхэн дүгнэх вэ?  
 А. Зарим үгсийн найруулгын доод зэргийг хүмүүс мэдэхгүй учир ингэж бичих нь тохиромжгүй.  
 В. Зөвхөн сонин нийтлэлийн найруулгад хэрэглэдэг тул найруулгын алдаа болно.  
 С. Үгийн өнгө аяс, өгүүлэгчийн сэтгэл хөдлөлийг бүрэн илэрхийлэхэд дөхөмтэй учир найруулгын зэргээр бичсэн нь оновчтой.  
 D. Доромж утгатай үгсээр утга шилжүүлэн дүрслэх нь тохиромжгүй.  
 E. Судар номын эрхэмсэг дээд найруулгыг зарим хүн ойлгохгүй тул дунд найруулгаар бичих нь зөв.
29. "осолдохооргүй" гэдэг үгийн нэрээс үйл үг бүтээх дагаврыг олоорой.  
 А. –л В. –д С. –х D. –оор E. –гүй
30. Эхээс сонгосон үгсээс бүтцээр нь зөв задалсныг олоорой.  
 А. алх+л+0+0+саар В. дус+л+0+тал С. гол+гд+моор  
 D. оосор+ло+0+ж E. өртөө+л+н
31. Зохисгүйдэх утгыг үүсгэсэн "-д" дагавартай бүлэг үгийг олоорой.  
 А. Саваадах, ташуурдах, шавхуурдах, сүхдэх  
 В. Уртдах, богинодох, нарийдах, томдох  
 С. Хөгжимдөх, хуурдах, лимбэдэх, хуучирдах  
 D. Чихдэх, сүүлдэх, хүзүүдэх, хөлдөх  
 E. Хонгодох, цохдох, шанаадах, элэгдэх
32. "Үнээгээ түргэхэн шиг шувтарчихаад цаад бүсгүйдээ шөл хийж өг. Би завиа янзалъя. Нөгөө давирхай хаана байгаа вэ? Завины ёроолоор ус шүүрээд байх болчхож..." – өгүүлбэрүүдээс алдаатай бичсэн нэг үгийг зөв болгон зассаныг олоорой.  
 А. шувтарчхаад В. түрэгхэн С. янзлая D. завьны E. болчихож
33. Бусдын эрхэнд үйлдэгдэх хэвийн дагаврыг **найруулгын алдаатай** хэрэглэсэн жишээг олоорой.  
 А. Баянгийн энгэрийн намаржаанд хоёр гэр харагдана.  
 В. Бурхны төлөө хийгдсэн ажил нь мөнхийн үр дагавартай байдаг.  
 С. Тулга дүүрэн утаа баагьж, хэн байгаа нь мэдэгдэхгүй байлаа.  
 D. Энэ хээр моринд гүйцэгддэггүй адуу үгүй.  
 E. Дулмаа эртэч болжмор мэт шулганан жиргэх охиныхоо дуунд бүүвэйлэгдэн дугхийжээ.
34. "Тэр сайхан талбайд гишгэх гутал олдох болов уу гэсэн **шүү** юм санагдаж" - онцолсон баймж бүтээврийн утгатай хамгийн ойр хэсэг аль нь вэ?  
 А. "Хятад хүн хялгасан дээгүүр гүйдэг гэж үнэн юм даа" гэсэн **шүү** юм бодно.  
 В. Сэлэнгэ ээж маань үерлэчхээд байхдаа нээрээ сүртэй **шүү**.  
 С. Тэргүүнээ газарт шигдтэл гулзайн нумартсан ч гэсэн үерт ховх явчихгүй тэсээд байна **шүү**.  
 D. Сар удахгүй шингэчихнэ **шүү** гэснээ суудлаа засаж, хормойгоо цуглуулаад морио гуядан дэргүүллээ.  
 E. Бодолтойхон явахгүй бол хүнд ч, өөртөө ч гай зовлон болно **шүү**.

35. Утга төгс өгүүлбэр бүтээхэд цэгийн оронд аль бүтээврүүд дарааллаараа тохирох вэ?  
 “Орчлон ертөнц... хоосон гэж хүрдийг бясалга..., винай... ёсыг сахь... гэвш Лодон”  
 A. –д, -ж, -аас, -сан      B. –ийг, -ж, -н, -сан      C. –өөс, -ж, -н, -я  
 D. –ийг, -ж, -д, -даг      E. –ийн, -н, -аас, -сан

36. Алдаагүй бичсэн өгүүлбэрийг олоорой.

- |                                  |                                  |                                  |                                  |                                  |
|----------------------------------|----------------------------------|----------------------------------|----------------------------------|----------------------------------|
| A                                | B                                | C                                | D                                | E                                |
| Өгүүлбэр<br>Өгүүлбэр<br>Өгүүлбэр | Өгүүлбэр<br>Өгүүлбэр<br>Өгүүлбэр | Өгүүлбэр<br>Өгүүлбэр<br>Өгүүлбэр | Өгүүлбэр<br>Өгүүлбэр<br>Өгүүлбэр | Өгүүлбэр<br>Өгүүлбэр<br>Өгүүлбэр |

37. Цэгийн оронд цагт нэрийн тохирох дагаврыг дарааллаар нь нөхөж, зүйр цэцэн үг бүтээгээрэй.

- |                                  |                                  |                                  |                                  |                                  |                                  |
|----------------------------------|----------------------------------|----------------------------------|----------------------------------|----------------------------------|----------------------------------|
| Өгүүлбэр<br>Өгүүлбэр<br>Өгүүлбэр | A                                | B                                | C                                | D                                | E                                |
| Өгүүлбэр<br>Өгүүлбэр<br>Өгүүлбэр | Өгүүлбэр<br>Өгүүлбэр<br>Өгүүлбэр | Өгүүлбэр<br>Өгүүлбэр<br>Өгүүлбэр | Өгүүлбэр<br>Өгүүлбэр<br>Өгүүлбэр | Өгүүлбэр<br>Өгүүлбэр<br>Өгүүлбэр | Өгүүлбэр<br>Өгүүлбэр<br>Өгүүлбэр |

38. “Монголын нууц товчоо” зохиолд Жамуха:

“Өөр төрлийн би  
 Өндөр төрөлт андын  
 Өмөг сүлдэнд дарагдав  
 Хэлсэн үгийг минь мартаггүй  
 Хэзээ ямагт дурдаж яваарай ...” хэмээн хэнд хандан өгүүлдэг вэ?

- A. Таян хаан    B. Тоорил хан    C. Алтан, Хучар    D. Тэмүжин    E. Сача бэхи

39. “Монголын нууц товчоо” зохиолын:

“Сүүдрээ довтлох  
 Сүрхий араатан мэт  
 Цугийг залгих  
 Цурхай загас мэт ” - хэсэгт ямар дүрслэх хэрэглүүр илэрч байна вэ?

- A. Егөөдөл      B. Тойруулал      C. Ёгтлол  
 D. Ихэсгэсэн зүйрлэл      E. Төлөөлөл

40. Дараах зохиолуудын хэсгийг нэртэй нь харгалзуулаарай.

- |   |  |
|---|--|
| 1. Бөөрийн даваа өгсөж яваад ах минь мориноосоо бууж,<br>“Бурхан шүтсэнээс өөр надад хийсэн гэм үгүй, намайг<br>одоо үгүй хийгээд аль” гэж цурхиран уйлав.<br>2. Цэнхэрлэн харагдах уул нь<br>Чандмань эрдэнийн уул аа<br>3. Тэргэл саран туулж баралгүй хээр хонодог<br>Тэнгэрийн хэвтэр буурал тал минь<br>4. Жаргал зовлонг энэ улстай холбон хамтатгасан<br>зовлого биеийг минь зовлонт боловч зоригт Монголын<br>нутагт оршуул! Төр чинь мөнх биш, түмэн мөнх юм!<br>5. Эцэг эхээ санагалзаж<br>Эгшиглэж шүлэглэсэн нь энэ байна | a. С.Эрдэнэ “Сэрүүн дуганы мөхөл” тууж<br>b. Б.Лхагвасүрэн “Боржигоны бор тал” шүлэг<br>c. Д.Нацагдорж “Учиртай гурван толгой” жүжиг<br>d. Ц.Дамдинсүрэн “Буурал ээж” найраглал<br>e. Б.Ринчен “Гүнж” өгүүллэг |
|---|--|

- A. 1a2c3b4e5d    B. 1c2a3b4d5e    C. 1a2d3c4e5b    D. 1d2a3b4e5c    E. 1e2c3a4b5d

## ХОЁРДУГААР ХЭСЭГ. ХАРГАЛЗУУЛАХ ДААЛГАВАР

### Санамж:

1. Энэ хэсэг сонгох даалгавар биш тул харгалзааг зөв тогтоож, хариуг бөглөөрэй.
2. Зөв харгалзуулсан хариулт бүр 1 оноотой.

2.1 Аман зохиолыг төрөл зүйлтэй нь зөв харгалзуулаарай.

- |  |                        |
|--|------------------------|
| a. Эрхийн чинээ биетэй<br>Эр хонгор дуутай               | 1. Дом шившлэг         |
| b. Арвайн гурил ус даадаг<br>Аавын хүү үг даадаг         | 2. Бэлгэ дэмбэрлийн үг |
| c. Алаг шавар алга<br>Араг савар олго                    | 3. Оньсого             |
| d. Тэнгэрийн од унаснаас биш<br>Миний од унаагүй         | 4. Хэл зүгшрүүлэх үг   |
| e. Буцалсан цай нь бурам бол<br>Буусан айл минь баян бол | 5. Зүйр цэцэн үг       |

2.2 “Ус уухын заяа” зохиолын хэсгээс авсан дараах үгсийн утгын тайлбарыг зөв харгалзуулаарай.

- |            |   |
|------------|---|
| a. Онгоц   | 1. Гэнэт зайлан зугтах  |
| b. Цулбуур | 2. Морь малын мундааны орчмын хяргаагүй үлдээсэн хэсэг                    |
| c. Шилгээх | 3. Морь малыг хөтлөх, уяхад зориулж хазаарын амгай зуузайнд бэхэлсэн дээс |
| d. Зулрах  | 4. Морь малын биеэ сэгсэрхийлэх   |
| e. Хур дэл | 5. Малд тэжээл, ус өгөх гонзгой хэлбэртэй хэрэгсэл                        |

2.3 Зөвийг нь олж харгалзуулаарай.

|   |   | 1             | 2             | 3             | 4              | 5              |
|---|---|---------------|---------------|---------------|----------------|----------------|
| a | Гийгүүлэгчээр төгссөн үгэнд урт эгшгээр эхэлсэн залгавар залгахад эцсийн гийгүүлэгчийн өмнөх балархай эгшиг гээгдэхгүй үг | урлаг+<br>аар | хадаг+<br>аар | гэээг+<br>ээр | таавар+<br>аар | намтар+<br>аар |
| b | Асуух утгатай “бэ?” баймж бүтээврийг дагуулах үг  | хаана         | хэн           | юу            | хэд            | яах            |
| c | Зөөлний тэмдэг “и” болохгүй үг  | дахь+н        | барь+х        | халь+ж        | тахь+л         | урь+лга        |
| d | Эр үгэнд “-ий” бичих үг   | хаалга        | аяга          | орц           | шанага         | толь           |
| e | Олноор үйлдэх байдлын “-цгаа <sup>4</sup> ” дагаврыг шууд залган бичих үг   | яв            | унш           | бич           | сонс           | оч             |

2.4 Хэрэглээний бичвэрийг жишээтэй нь харгалзуулаарай.

- |   |             |
|---|-------------|
| a. Миний аав дуулсан, үзсэн, биеэр эдэлсэн бүхнээ хэсэг хэсгээр нь цэгцтэй ярьж өгөх дуртай хүн байсан юм.                  | 1. Өргөдөл  |
| b. Зохиолч Д.Нацагдорж 1906 онд Түшээт хан аймгийн Дархан чин вангийн хошуу, одоогийн Төв аймгийн Баяндэлгэр суманд төржээ. | 2. Захидал  |
| c. Дээрх дадлага туршлагыг минь харгалзан үзэж, ажилд авна уу?  | 3. Зөвлөгөө |
| d. Зохиолоо бүрэн эхээр нь уншвал утгын гүнд нэвтрэхэд тань дөхөм болдог юм шүү.  | 4. Дурсамж  |
| e. Намсрай минь сайн байна уу?  | 5. Намтар   |

